



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ГУРВАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 1/44

Пионер толгой

Бактержуулсан будаа цацаж үлийн цагаан
оготной тэмцэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 10/02 тоот тогтоолыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Бэлчээрийн хортон мэрэгч, үлийн цагаан оготной тэмцэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

2. Бэлчээрийн хортон мэрэгч, үлийн цагаан оготной тэмцэх ажлыг холбогдох заавар журмын дагуу чанартай зохион байгуулахыг ажлын хэсэгт даалгасугай.


3. Бэлчээрийн хортон мэрэгч, үлийн цагаан оготныг бактержуулсан будаагаар устгах ажлын явц, биелэлтэд байнгын хяналт тавьж дүгнэлт гарган ажиллахыг Байгаль орчны хяналтын Улсын байцаагч Ш.Нархүүд даалгасугай.

4. Ажлын хэсгийн гишүүд, гэрээгээр ажиллаж буй иргэдэд эрүүл ахуй, хөдөлмөр хамгааллын талаар мөрдөх зааврыг танилцуулж сургалт, зөвлөгөө өгч ажиллахыг хөдөө аж ахуйн тасгийн дарга М.Ариунсанд үүрэг болгосугай.

5. Бактерийн бэлдмэл цацах нутаг дэвсгэрт хорио цээрийн дэглэм тогтоож малчид, иргэдэд дэглэм, заавар шаардлагыг танилцуулж мөрдөн ажиллахыг багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

6. Үлийн цагаан оготной бактержуулсан будаагаар тэмцэх ажлын явц, үр дүнг нэгтгэн тайлан бичиж Засаг даргаар баталгаажуулж, аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт хүргүүлэхийг хөдөө аж ахуйн тасгийн дарга М.Ариунсанд даалгасугай.

ДАРГА  Б. ГАНТУЛГА



642201273